



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 08 сарын 19 өдөр

Дугаар А/422

Хэрлэн сум

“Зүүн бүсийн чуулган”-д оролцоход  
хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.3, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 10 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт тусгагдсан Залуучуудын хөгжлийн салбар зөвлөлийн туршлага солилцох, цаашдын үйл ажиллагааг идэвхжүүлэх арга хэмжээний хүрээнд Хэнтий аймгийн Залуучуудын холбоо, залуучуудын төлөөлөл Монголын залуучуудын байгууллага үүссэний 100, 101 жилийн ойн хүрээнд зохион байгуулагдаж буй “ЗҮҮН БҮСИЙН ЧУУЛГАН”-д оролцох зардалд зориулж 3,000,000 (гурван сая) төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.

2. Зардлын тооцоог хавсралтаар баталсугай.

3. Дээрх зардалд шаардагдах хөрөнгийг Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний “Залуучуудын дэд хөтөлбөр” зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (С.Нямдаваа)-д, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтсийн дарга (Д.Өнөрцэцэг)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ

Аймгийн Засаг даргын 2022  
оны 08 дугаар сарын 19-ны  
09/19/22 захирамжийн хавсралт

Шаардагдах зардлын тооцоо

№	Зардлын нэр	Тоо	Нэг бүрийн үнэ	Бүгд үнэ
1	"ЗҮҮН БҮСИЙН ЧУУЛГАН"-д оролцох зардал	1	3,000,000	3,000,000
Нийт				3,000,000